



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/594

Булган сум

┌ Ургацын штаб ажиллуулах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1, Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ургац хураалт, хадлан бэлтгэлийн ажлын мэдээлэл хүлээн авах аймгийн ургацын штабыг Хүнс, хөдөө аж ахуйн газарт 09 дүгээр сарын 01-нээс эхлэн ургац хураалт дуусталх хугацаанд 8:00-20:00 цаг хүртэл ажиллуулсугай.

2. Ургацын комиссын сумдад ажиллах шатахууны зардалыг хавсралтаар баталж, шаардагдах 4,500,000 (дөрвөн сая таван зуун мянга) төгрөгийг “Газар тариалангийн тогтвортой хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3. Ургац хураалтын ажлыг мэргэжил арга зүйгээр хангаж, технологит хугацаанд нь багтааж шуурхай зохион байгуулахыг ургацын штаб (Д.Жаргалсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

16323010840